



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 09 сарын 12 өдөр

Дугаар А/404

Мандалговь

Газар эзэмших эрхийг
шилжүүлэх тухай

Монгол улсын Газрын тухай хуулийн 38 дугаар зүйл 38.1, 38.2, 38.4, 38.6 дахь заалт, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь заалт, газар эзэмших эрхийг шилжүүлэн авах иргэний хүсэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

Нэг. Сайнцагаан сумын төвийн 7 дугаар багийн нутаг дэвсгэр (Нэгдсэн эмнэлгийн баруун талд Худалдааны гудамж-2-213)-т байршилтай иргэн Сумъяа овогтой Бат-эрдэнэ (ЗЛ:68052211)-ийн орон сууцны зориулалттай 144 м.кв (0,01 га) газрыг "ТЭББЭ" ХХК (РД:2012545)-д үйлвэрлэл үйлчилгээний зориулалтаар шилжүүлж 22 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

Хоёр. Дээрх аж ахуй нэгжтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Э.Чагнаадорж), мөн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг ГХБХБГазар, Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч (Р Мөнхтогтох), аймгийн Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат) нарт тус тус үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2010 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн А/502 тоот захирамжийн "ТЭББЭ" ХХК-д холбогдох хэсэг мөн газар эзэмших 0353893 тоот гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О БАТ-ЭРДЭНЭ

483910294